

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр****Улаанбаатар хот****АКТИВ УДИРДЛАГЫН ТУХАЙ****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ****Нийтлэг үндэслэл****1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Монгол Улсын Актив Удирдлагын Компани /цаашид “Актив удирдлагын компани” гэх/-ийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, хяналтын эрх зүйн үндэс болон эрхлэх үйл ажиллагааны хүрээг тогтоож, зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Актив удирдлагын тухай хууль тогтоомж

2.1.Актив удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Төв банк /Монголбанк/-ны тухай хууль³, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль⁴, Банкны тухай хууль⁵, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“банк” гэж Банкны тухай хуулийн 3.1.1-д заасан хуулийн этгээдийг;

3.1.2.“зах зээлийн бодит үнэ” гэж талууд өөрсдийн мэдээлэл, хүсэл зоригт тулгуурлан аливаа дарамт шахалтгүйгээр бие даан хийсэн хэлцэлд үндэслэн худалдан авагч талаас худалдагч талд төлөх мөнгөн дүн;

3.1.3.“тохиромжтой этгээд” гэж шударга, итгэл даах, мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн болон зохистой шийдвэр гаргах чадвар бүхий Актив удирдлагын компанийн удирдах албан тушаалтныг;

3.1.4.“чанаргүй актив” гэж доор дурдсан хөрөнгийг:

3.1.4.а.чанаргүй зээл;

¹Монгол Улсын Үндсэн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³Төв банк /Монголбанк/-ны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

⁴Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2005 оны 46 дугаарт нийтлэгдсэн

⁵Банкны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.1.4.б.чанаргүй зээлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор шилжүүлэн авсан, эсхүл банк өөрийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор худалдахаар төлөвлөсөн бусад актив.

3.1.5.“чанаргүй зээл” гэж Монголбанк, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан журмаар тодорхойлсон активыг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИ,

ТҮҮНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ

4 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийг үүсгэн байгуулах, түүний эрх зүйн байдал

4.1.Актив удирдлагын компани нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкнаас энэ хуульд тодорхойлсон чанаргүй активыг шилжүүлэн авах, түүнтэй холбогдох үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

4.2.Актив удирдлагын компанийн төв Монгол Улсын нийслэлд байрлана.

4.3.Актив удирдлагын компани дүрэмтэй байх бөгөөд дүрмийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрсөнөөр хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална.

4.4.Актив удирдлагын компани тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4.5.Энэ хуулийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө, өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор Актив удирдлагын компани нь хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг эрхэлж болно.

4.6.Актив удирдлагын компанийг байгуулах, өөрчлөн байгуулах, энэ хуулийн 51.1-т заасны дагуу татан буулгах шийдвэрийг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвшөөрсөнөөр хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана.

5 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

5.1.Актив удирдлагын компани үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.үйл ажиллагаагаа тогтвортой явуулах;
- 5.1.2.хараат бус байх;
- 5.1.3.ашигтай ажиллах;
- 5.1.4.ил тод байх;

5.1.5. хариуцлагатай байх.

6 дугаар зүйл. Актив удирдлагын компанийн бие даасан байдал

6.1. Актив удирдлагын компани, түүний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан энэ хуульд заасан эрх, албан үүргээ хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус, бие даасан байна.

6.2. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан нь өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, Актив удирдлагын компанийн нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн дээдэлнэ.

6.3. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан нь албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ аливаа улс төрийн үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөлд автахыг хориглоно.

7 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилахыг хориглох

7.1. Актив удирдлагын компани Засгийн газрын баталгаа гаргасан эх үүсвэрийг бүрэн төлж барагдуулахаас өмнө аливаа хэлбэрээр ногдол ашиг хуваарилахыг хориглоно.

8 дугаар зүйл. Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавих

8.1. Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.

8.2. Санхүүгийн зохицуулах хороо шаардлагатай гэж үзсэн, эсхүл Монголбанкнаас хүсэлт тавьсан бол Актив удирдлагын компанийн үйл ажиллагаа, данс бүртгэл, тайлан, тэнцэл, санхүүгийн баримтад хяналт шалгалт хийж болно.

8.3. Актив удирдлагын компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ, удирдлага, зохион байгуулалт, бүтэц, удирдлагын эрх хэмжээг нарийвчлан тогтоосон журмыг Санхүүгийн зохицуулах хороо батална.

8.4. Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэлийн тусгай журам, тус компанийн санхүүгийн тайланд тавих шаардлагыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

8.5. Энэ хуульд заасан чанаргүй зээлийг тодорхойлох журмыг Монголбанк, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

8.6. Актив удирдлагын компани, түүний үйл ажиллагаа, удирдлага, санхүүжилт, хяналт шалгалт, актив удирдлагын сан, түүний үйл ажиллагаанд холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо дангаар буюу Монголбанк, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

9 дүгээр зүйл. Мэдээлэлд нэвтрэх, мэдээллийг ашиглах, солилцох

9.1. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтан нь албан үүргийнхээ дагуу олж авсан аливаа

мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг хориглоно:

9.1.1. тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

9.1.2. шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авилгатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн;

9.1.3. энэ хуульд заасны дагуу Актив удирдлагын компанид хийх хөндлөнгийн аудиттай холбогдуулан хүссэн;

9.1.4. Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанкнаас өөрийн хянан шалгах чиг үүргийн хүрээнд шаардсан болон Санхүүгийн зохицуулах хорооны байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу гадаад улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан.

10 дугаар зүйл. Актив удирдлагын компани, түүний албан тушаалтны баталгаа

10.1. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтнаас эрх хэмжээнийхээ хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл түүнийг биелүүлснээс банк, гуравдагч этгээдэд учирсан хохирлыг Актив удирдлагын компани, түүний ажилтан, албан тушаалтан хариуцахгүй.

10.2. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтныг хуулиар хүлээлгэсэн албан үүрэгтэй нь холбоотойгоор заналхийлэх, сүрдүүлэх, амь бие, эрүүл мэндэд нь халдах аливаа хууль бус үйлдлээс тэдгээрийг болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамгаалах үүргийг Актив удирдлагын компани хүлээнэ.

10.3. Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, ажилтан, албан тушаалтан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэнд нь хохирсон буюу амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний гэр бүлд Актив удирдлагын компаниас тогтоосон журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, зардлыг олгоно.

11 дүгээр зүйл. Актив удирдлагын компани, түүний албан тушаалтны үйл ажиллагаанд холбогдох гомдлыг шийдвэрлэх, нөхөн төлбөр олгох

11.1. Актив удирдлагын компани, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, ажилтан, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэлд гомдол гаргах тохиолдолд тухайн этгээд гомдлоо төлөөлөн удирдах зөвлөлд гаргах бөгөөд уг гомдолд тухайн нөхцөл байдал, хууль зүйн үндэслэл, хохирлын хэмжээг тусгана.

11.2. Энэ хуулийн 11.1-д заасан гомдлыг төлөөлөн удирдах зөвлөл хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд энэ хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу гомдол гаргагчийг дуудан сонсгол хийнэ.

11.3.Энэ хуулийн 11.2-т заасан сонголд гомдол гаргагч, Актив удирдлагын компанийн төлөөлөл болон Актив удирдлагын компаниас оролцуулах шаардлагатай гэж үзсэн этгээдийг оролцуулна.

11.4.Төлөөлөн удирдах зөвлөл гомдол гаргагч этгээдэд энэ зүйлд заасны дагуу нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн тохиолдолд Актив удирдлагын компани нөхөн төлбөрийг зөвхөн нотлогдсон хэмжээгээр төлнө.

11.5.Актив удирдлагын компани энэ хуульд заасны дагуу олгосон нөхөн төлбөрийг холбогдох буруутай этгээдээс гаргуулан авч болно.

11.6.Төлөөлөн удирдах зөвлөл гомдол гаргагч этгээдийн гомдлыг үндэслэлгүй гэж үзэж нөхөн төлбөр олгохгүй байхаар шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргагч шүүхэд хандах эрхтэй.

11.7.Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтны хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад энэ хуулийн 10.1, 11.8-д зааснаас бусад байдлаар бусдад учруулсан хохирлыг Актив удирдлагын компани тэдгээрийн өмнөөс хариуцан барагдуулна.

11.8.Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтны хууль бусаар бусдад санаатайгаар учруулсан хохирлыг Актив удирдлагын компани хариуцахгүй. Актив удирдлагын компани тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, албан тушаалтны санаатайгаар учруулсан хохирлыг уг этгээд гэм буруутай болохыг мэдэхээс өмнө төлсөн тохиолдолд уг нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулан авах эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН САНХҮҮЖИЛТ

12 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн санхүүжилт

12.1.Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө тус компанийн дүрэмд заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

12.1.1.төр, бусад этгээдээс хувь нийлүүлсэн хөрөнгө, олон улсын санхүүгийн байгууллага, гадаад улсын төрийн актив удирдлагын компанийн оруулсан хөрөнгө;

12.1.2.хуульд заасан бусад эх үүсвэр.

12.2.Актив удирдлагын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 20 хувийг төрөөс бүрдүүлнэ.

13 дугаар зүйл.Өрийн хэрэгсэл гаргах

13.1.Актив удирдлагын компани төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу өрийн хэрэгсэл гаргаж болно.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан өрийн хэрэгсэлд Засгийн газар баталгаа гаргаж болно.

14 дүгээр зүйл.Зээл авах

14.1.Актив удирдлагын компани төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу энэ хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх зорилгоор гадаад, дотоод эх үүсвэрээс зээл авч болно.

15 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн хөрөнгө оруулалт

15.1.Актив удирдлагын компани өөрийн актив хөрөнгийг аюулгүй, хөрвөх чадвартай, ашигтай байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд байршуулж болно:

15.1.1.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авсан, зээлжих зэрэглэл тогтоодог олон улсын байгууллагаар үнэлгээ хийлгэсэн банканд хадгаламж байршуулах;

15.1.2.Засгийн газрын үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргасан бусад үнэт цаас;

15.1.3.Актив удирдлагын компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан бодлого, журмын дагуу бусад хөрөнгө оруулалт.

16 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн санхүүгийн бусад эх үүсвэр

16.1.Актив удирдлагын компани төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан бодлого, журмын хүрээнд өөрийн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах зорилгоор зээл авч, хөрөнгө оруулалт хийж, бусад эх үүсвэрээс санхүүжилт авч болно.

17 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд тавих хязгаарлалт

17.1.Актив удирдлагын компанийн гаргах өрийн хэрэгсэл нь нийт дүнгээрээ өөрийн хөрөнгийг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна.

17.2.Энэ хуулийн 13.2-т заасны дагуу Засгийн газар баталгаа гаргах бол энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

18 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн дүрэм

18.1.Актив удирдлагын компанийн дүрэмд дараах зүйлийг тусгана.

18.1.1.компанийн нэр болон хаяг;

18.1.2.компанийн зорилго;

18.1.3.компанийн үйл ажиллагааны чиглэл;

18.1.4.компанийн хөрөнгө;

18.1.5.компанийн бүтэц, зохион байгуулалтын хэлбэр;

18.1.6.төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны эрхлэх үйл ажиллагаа, чиг үүрэг, хариуцлага;

18.1.7.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэр гаргах зарчим;

18.1.8.бусад.

19 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн бүтэц, зохион байгуулалт

19.1.Актив удирдлагын компани нь төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах бусад ажилтан, албан тушаалтантай байна.

20 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

20.1.Актив удирдлагын компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний чөлөөт цагт төлөөлөн удирдах зөвлөл байна.

20.2.Актив удирдлагын компанийн хувьцаа эзэмшигч нь, Монгол Улсын Засгийн газар болон энэ хуульд заасан бусад этгээд байна.

21 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл

21.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь долоон гишүүнтэй байх ба дөрвөн гишүүн нь хараат бус гишүүн байна.

21.2.Компанийн тухай хуулийн 62.1.7-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгож, бүрэн эрхийг дуусгавар болгоно.

21.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Азийн хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци тус тус нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурал сонгоно.

21.4.Гүйцэтгэх захирал төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болно.

21.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараах шаардлагыг хангасан байна:

21.5.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өрийн үлдэгдэлгүй;

21.5.2.банк, санхүү, хууль, эдийн засгийн дээд боловсролтой;

21.5.3. мэргэжлээрээ тав буюу түүнээс дээш жил, удирдах албан тушаалтнаар хоёр буюу түүнээс дээш жил ажилласан байх;

21.5.4. тохиромжтой этгээд байх.

21.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нэгээс доошгүй гишүүн доор дурдсан салбараар мэргэшсэн байна:

21.6.1. банк, санхүү, эдийн засаг;

21.6.2. нягтлан бодох бүртгэл, аудит, санхүүгийн тайлагнал;

21.6.3. эрх зүй;

21.6.4. хөрөнгийн үнэлгээ, удирдлага, худалдаа.

21.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг таван жилийн хугацаагаар сонгох бөгөөд нэг удаа улируулан сонгож болно. Актив удирдлагын компанийн бодлогын залгамж халааг хадгалах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг дахин сонгохдоо эхний сонгосон дөрвөн гишүүнийг гурван жилийн хугацаагаар, дараагийн гурван гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар тус тус сонгоно.

21.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

22 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

22.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль, Актив удирдлагын компанийн дүрэм болон тус компанийн бодлого, журмын хүрээнд үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах бөгөөд Компанийн тухай хуулийн 76.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1. Актив удирдлагын компанийн зохион байгуулалтын бүтцийг энэ хуулийн 8.2-т заасан журамд нийцүүлэн батлах;

22.1.2. Актив удирдлагын компанийн бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааны дүрэм, журам, заавар батлах;

22.1.3. гүйцэтгэх удирдлагыг сонгох, чөлөөлөх, бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшуулал, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох;

22.1.4. бусад эрх бүхий албан тушаалтныг сонгох, бүрэн эрхийг дуусгавар болгох, Актив удирдлагын компанийн дүрэм болон дотоод дүрэм, журмын дагуу тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих;

22.1.5. Актив удирдлагын компанийн стратегийг тодорхойлох, жилийн төсөв, төлөвлөгөөг, санхүүгийн тайланг батлах;

22.1.6. Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шаардлагатай гэж үзвэл холбогдох арга хэмжээг авах;

22.1.7.Актив удирдлагын компанийн аливаа хөрөнгийг эзэмших, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан дүрэм, журам баталж, тус асуудлаарх гүйцэтгэх удирдлагын холбогдох эрх хэмжээг тогтоох;

22.1.8.дотоод аудитын нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх;

22.1.9.төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын хороо, эрсдэлийн удирдлагын хороо болон бусад хороог байгуулж, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлох;

22.1.10.Актив удирдлагын компанийн хөрөнгө оруулалтын бодлогыг батлах;

22.1.11.баталгаа гаргах дээд хэмжээг тогтоох;

22.1.12.активт үнэлгээ хийх үнэлгээчин, хөндлөнгийн аудитыг сонгох, томилох;

22.1.13.энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан зээлийн хэмжээг тогтоох;

22.1.14.Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүү, үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, холбогдох стандартын хэрэгжилтийг хангуулах;

22.1.15.Энэ хууль болон Актив удирдлагын компанийн дүрэмд заасан бусад бүрэн эрх.

22.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлан ажиллана:

22.2.1.Актив удирдлагын компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд тавьж, албан үүргээ үнэнч, шударгаар биелүүлэх;

22.2.2.мэргэжил, ур чадварын өндөр түвшинд ажиллах;

22.2.3.бие даасан, хараат бус байж, бусдын нөлөөнд үл автан, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх.

23 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг түр чөлөөлөх

23.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг доор дурдсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын ээлжит бус хурлын шийдвэрээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно:

23.1.1.энэ хуулийн 21.5-д заасан шаардлагын аль нэгийг хангахгүй болсон;

23.1.2.биеийн эрүүл мэндийн болон хүндэтгэх үзэх шалтгаанаар албан үүргээ зургаан сараас дээш хугацаагаар гүйцэтгэх боломжгүй болсон;

23.1.3.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сүүлийн гурван удаагийн хуралд дараалан оролцоогүй;

23.1.4.үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлж, Актив удирдлагын компанийн эрх ашигт харш үйлдэл, эс үйлдэл гаргаж, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн,23.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн

гишүүн албан тушаалаасаа түр чөлөөлөгдөх хүсэлтийг төлөөлөн удирдах зөвлөлд гаргаж болох бөгөөд уг хүсэлтэд түр чөлөөлөгдөх хугацааг тодорхой тусгана. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг албан тушаалаас түр чөлөөлнө.

24 дүгээр зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нөхөн сонгох, орлон ажиллах

24.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрх энэ хуулийн 23.1-д заасны дуусгавар болсон бол тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн этгээд түүний оронд ажиллах гишүүнийг нөхөн нэр дэвшүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгоно.

24.2.Нөхөн сонгогдож байгаа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн энэ хуулийн 21.5-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд чөлөөлөгдсөн гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаагаар ажиллана.

24.3.Энэ хуулийн 23.2-д заасны дагуу түр чөлөөлөгдсөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлон ажиллах энэ хуулийн 21.5-д заасан шаардлагыг хангасан этгээдийг төлөөлөн удирдах зөвлөл түр хугацаагаар томилно.

24.4.Энэ хуулийн 24.3-т заасан түр хугацаагаар ажиллах этгээдийн ажиллах хугацааг нэр дэвшүүлсэн этгээд тогтооно.

25 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

25.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд түүний томилсон этгээд удирдана.

25.2.Актив удирдлагын компанийн дүрэмд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл нь жилд дөрөв буюу түүнээс дээш удаа хуралдах бөгөөд үүнээс хоёр хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд биечлэн оролцохоор зохион байгуулна. Утсаар болон мэдээллийн технологийн техник хэрэгсэл, программ хангамж ашиглаж хуралд оролцож саналаа өгч болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд жилд хоёр буюу түүнээс дээш удаа хуралд биечлэн оролцоно.

25.3.Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлагын санал болгосны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн дарга хэлэлцэх асуудлыг баталж, тус зөвлөлийн бүх гишүүдэд мэдэгдэж, төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулна.

25.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хоёр гишүүнээс бичгээр санал гаргасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулж болно.

25.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулахаас ажлын 10 хоногийн өмнө хурлын тов, хурал болох газар, хурлаар хэлэлцэх асуудлыг тус зөвлөлийн бүх гишүүдэд хүргүүлж мэдээлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд мэдэгдэж болно.

25.6.Төлөөлөн удирдах зөвлөлийг бүх гишүүдийн дийлэнх олонхийн ирцтэйгээр хуралдуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

25.7.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Санал хураалтын дүн тэнцсэн нөхцөлд төлөөлөн удирдах зөвлөлийн даргын саналаар шийдвэрлэнэ.

25.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, хуралд оролцогчдын саналын баримт бичгийн баталгаажуулсан хувийг төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд хүргүүлнэ.

26 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо

26.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хороо ба эрсдэлийн удирдлагын хороог байгуулна.

26.2.Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор байнга болон түр хугацаанд үйл ажиллагаа эрхлэх бусад хороог нэмж байгуулж болно.

26.3.Хороо нь төлөөлөн удирдах зөвлөлийн гурван гишүүнээс бүрдэх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, зөвлөмж, дүрэмд нийцүүлж үйл ажиллагаа явуулна.

26.4.Аудитын хороо нь Компанийн тухай хуулийн 81.4-т заасан болон Актив удирдлагын компанийн дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын асуудал болон эдгээртэй холбоотойгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс тодорхойлсон бусад ажил үүргийг гүйцэтгэж, төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөмж, зөвлөгөө хүргүүлж ажиллана.

26.5.Эрсдэлийн удирдлагын хороо нь Актив удирдлагын компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, цаашид хөгжүүлэх, сайжруулахад зөвлөж ажиллана.

27 дугаар зүйл.Дотоод аудитын үйл ажиллагаа

27.1.Төлөөлөн удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлэх дотоод аудитын нэгжийг байгуулна:

27.1.1.Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт тавьж, үнэлгээ өгөх;

27.1.2.Актив удирдлагын компани, түүний албан тушаалтан хууль тогтоомж, тус компанийн дүрэм, журам, захиргааны актыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах;

27.1.3.Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны доголдол, дутагдалд дүн шинжилгээ хийж, түүнийг арилгах, дахин гарахаас сэргийлэх арга хэмжээний талаарх санал, зөвлөмж өгөх;

27.1.4.энэ хуулийн 27.1.3-т заасан асуудлаар төлөөлөн удирдах зөвлөл, аудитын хороо болон гүйцэтгэх удирдлагатай уулзалт хийх;

27.1.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журмын дагуу тус зөвлөл, гүйцэтгэх удирдлагад Актив удирдлагын компанийн дотоод аудитын үйл ажиллагааны талаар дүгнэлт бэлтгэж хүргүүлэх;

27.1.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан журамд заасан бусад чиг үүрэг.

28 дугаар зүйл. Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлага

28.1.Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх бөгөөд түүний бүрэлдэхүүнд гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын орлогч, эрсдэл, санхүү, хууль, эрх зүйн асуудал хариуцсан удирдах албан тушаалтан ажиллана.

28.2.Гүйцэтгэх удирдлага нь дараах шаардлагыг хангасан байна:

28.2.1.тохиромжтой этгээд байх;

28.2.2.эдийн засаг, санхүү эсхүл хууль зүйн чиглэлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэгтэй байх;

28.2.3.энэ хуулийн 21.6-д заасан салбарт таваас дээш жил удирдах албан тушаалд ажилласан байх.

28.3.Гүйцэтгэх удирдлагыг таван жилийн хугацаанд орон тооны ажилтнаар ажиллах, улиран сонгогдох боломжтой нөхцөлөөр төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгоно.

28.4.Гүйцэтгэх удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлэх зарчим, ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, дүгнэх тухай Актив удирдлагын компанийн дүрэм, журамд заах бөгөөд гүйцэтгэх удирдлага төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрч баталсан дотоод бодлого, зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

28.5.Гүйцэтгэх удирдлага Актив удирдлагын компанийн өдөр тутмын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтыг хариуцах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

28.5.1.Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж, Актив удирдлагын компанийг төлөөлөх, удирдах;

28.5.2.Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг сайжруулах, энэ хууль болон бусад холбогдох журам, шаардлагын хэрэгжилтийг хангах талаар төлөөлөн удирдах зөвлөлд санал оруулах;

28.5.3.Актив удирдлагын компанийн жилийн санхүүгийн төлөвлөгөөг бэлтгэж танилцуулах, компанийн санхүүгийн тайланг танилцуулж батлуулах;

28.5.4.Актив удирдлагын компанийн хөрөнгө оруулалтын бодлогыг бэлтгэж, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах;

28.5.5.үйл ажиллагааны төлөвлөгөө, дүрэм, журам, тушаал болон заавар, удирдамжийн төсөл бэлтгэж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах;

28.5.6.Актив удирдлагын компанийн шилжүүлэн авах активт үнэлгээ хийх, активын удирдлагыг хэрэгжүүлэх хөндлөнгийн мэргэжлийн этгээд, актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд аудит хийх хөндлөнгийн аудитыг санал болгох;

28.5.7.энэ хууль болон төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан Актив удирдлагын компанийн дүрэм, журам, бодлогын дагуу тус компанийн ажилтан, албан тушаалтанг ажилд авах, ажлаас чөлөөлөх;

28.5.8.Актив удирдлагын компанийн эрсдэлийн үнэлгээний төлөв байдлыг дүгнэж, хүлээн зөвшөөрч болохуйц эрсдэл, энэ хууль, тус компанийн дүрэм, бодлого, журмын дагуу авах арга хэмжээг тодорхойлох.

28.5.9.энэ хууль болон Актив удирдлагын компанийн дүрэм, журам, бодлогын дагуу бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

28.6.Энэ хуулийн 28.5-т заасан чиг үүргийг гүйцэтгэх удирдлага багаар эсхүл гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлаас эрх олгосон гүйцэтгэх удирдлагын багын бусад гишүүд дангаар хэрэгжүүлж болно.

28.7.Гүйцэтгэх удирдлага нь Актив удирдлагын компанийн засаглалын стандарт болон төсөвт нийцсэн, төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон цалин, урамшуулал авна.

ТАВДУГААР БҮЛЭГ

АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

29 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн эрхлэх үйл ажиллагаа

29.1.Актив удирдлагын компани дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

29.1.1.энэ хуульд заасны дагуу чанаргүй активыг шилжүүлэн авах;

29.1.2.хөрөнгө, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг төлүүлэх, шаардлагатай тохиолдолд барьцаа, эрсдэлийн сангаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах зэргээр банкнаас шилжүүлэн авсан чанаргүй зээлийг өмчлөх, эзэмших, удирдах, захиран зарцуулах;

29.1.3.банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг сайжруулах эсхүл түүний үнэ цэнийг нэмэгдүүлэх, хамгаалах талаар дараах арга хэмжээг авах:

29.1.3.а.актив болон активын багцыг боломжит өндөр үнээр худалдан борлуулах, захиран зарцуулах;

29.1.3.б.чанаргүй активыг төлүүлэх, активт холбогдох этгээдийн актив хөрөнгийг шалгах, хамгаалах;

29.1.3.в.активын багцыг үнэт цаас гаргах болон бусад аргаар санхүүжүүлэх;

29.1.3.г.зээлийн барьцаа хөрөнгийг худалдан борлуулах, захиран зарцуулах, эзэмшилдээ авах, санхүүжүүлэх, барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах;

29.1.3.д.энэ хуулийн Зургадугаар бүлэгт заасны дагуу чанаргүй активын санг удирдах;

29.1.3.е.энэ хуульд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон бусад.

29.2.Актив удирдлагын компани хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ банкнаас шилжүүлэн авсан активын барьцаа болон түүнд хамаарах хөрөнгийг зах зээлд хэт төвлөрөл, үнэ, ханшийн огцом өөрчлөлт үүсгэхээс зайлсхийнэ.

29.3.Актив удирдлагын компани чанаргүй активыг шийдвэрлэх зах зээлийн зарчимд үндэслэсэн, иж бүрэн, үр нөлөөтэй аргачлалыг батална.

29.4.Актив удирдлагын компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан тус компанийн эзэмшиж, өмчилж байгаа хөрөнгийг худалдаж эсхүл шилжүүлэн авах эрхгүй.

30 дугаар зүйл.Банкны хүсэлтээр актив шийдвэрлэх үйл ажиллагаа

30.1.Банк Актив удирдлагын компанид өөрийн чанаргүй активын төлбөрийг шаардах, төлүүлэх, хөрөнгө худалдан борлуулах зэргээр чанаргүй активыг шийдвэрлэх эрхийг олгож болно.

30.2.Актив удирдлагын компани энэ хуулийн 30.1-т заасан хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд банкнаас олгосон хүрээнд чанаргүй активыг шийдвэрлэх, захиран зарцуулах арга хэмжээг нэн даруй авна.

30.3.Энэ хуулийн 30.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх бодлого, журмыг төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

31 дүгээр зүйл.Банкны чанаргүй активыг шилжүүлэн авах

31.1.Актив удирдлагын компани шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн дагуу банкнаас олгосон чанаргүй активыг шилжүүлэн авч болно.

31.2.Монголбанк энэ хуулийн 31.4, 31.5-д заасныг үндэслэн Актив удирдлагын компанид чанаргүй актив шилжүүлэх банкныг тодорхойлох нөхцөл, журмыг батална.

31.3.Энэ хуулийн 31.2-т заасан нөхцөл, журмын дагуу тодорхойлсон болон Монголбанк шийдвэрлэснээс бусад тохиолдолд Актив удирдлагын компани аливаа үндэслэлээр банкны чанаргүй активыг шилжүүлэн авах үүрэг хүлээхгүй.

31.4.Актив удирдлагын компани банкны чанаргүй активыг шилжүүлэн авах эсэхийг шийдвэрлэхдээ дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

31.4.1.банкны актив хөрөнгөд хамаарах барьцаа хөрөнгө зохих хэмжээнд байгаа эсэх;

31.4.2.банкны актив хөрөнгөд хамаарах барьцаа хөрөнгө баталгаажсан эсэх;

31.4.3.барьцаа хөрөнгийн үнэлгээ;

31.4.4.зээлийн хувийн хэргийн бүрдэл, эцсийн өмчлөгчийн мэдээлэл;

31.4.5.худалдагч банк эсхүл гуравдагч этгээд Актив удирдлагын компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх түүний шилжүүлэн авах барьцаа хөрөнгөд холбогдох үйл ажиллагаа эрхэлсэн эсэх;

31.4.6.банк шилжүүлэх актив хөрөнгөд холбогдох хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн эсэх;

31.4.7.үүрэг үүсгэсэн хэлцлийн дүн, түүнээс чанаргүй болсон активын хэмжээ;

31.4.8.барьцаа хөрөнгийн өмчлөх, эзэмших эрх зөрчилгүй байх;

31.4.9.чанаргүй активт барьцаалсан газарт холбогдох хууль, эрх зүйн, эрх бүхий этгээдийн аливаа шаардлага хангагдсан эсэх;

31.4.10.шилжүүлэн авах барьцаа хөрөнгө болон банкны бусад активын холбоо хамаарал;

31.4.11.барьцаа хөрөнгийн чанар;

31.4.12.банкны болон Актив удирдлагын компанийн шалгалтаар илэрсэн аливаа зөрчил;

31.4.13.Актив удирдлагын компанийн шилжүүлэн авсан буюу шилжүүлэн авахаар төлөвлөсөн бусад барьцаа хөрөнгийн төрөл;

31.4.14.тухайн активыг шилжүүлэн авах нь энэ хуульд нийцэх эсэх;

31.4.15.энэ хуулийн дагуу Актив удирдлагын компанийн шаардлагатай гэж үзсэн бусад.

31.5.Актив удирдлагын компани банкны чанаргүй активыг шилжүүлэн авахад тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох бөгөөд тэдгээрт дараах нөхцөлийг заавал тусгана:

31.5.1.банкны эзэмшиж байгаа чанаргүй активыг барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой байх;

31.5.2.шилжүүлэн авах чанаргүй активын барьцаа хөрөнгийг зах зээлд худалдан борлуулах боломжтой байх;

31.5.3.шилжүүлэх чанаргүй активын талаар банкнаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт бичиг нь бүрэн гүйцэд, үнэн зөв байх;

31.5.4.шилжүүлэх чанаргүй активтай холбоотой эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн баримт бичиг үнэн зөв, бүрэн байх;

31.5.5.бусад.

31.6.Актив удирдлагын компани банкнаас чанаргүй актив шилжүүлэн авахад эсвэл тус компани чанаргүй активыг бусад этгээдэд худалдахад зээлдэгчийн зөвшөөрлийг авахгүй.

32 дугаар зүйл.Чанаргүй активыг үнэлэх аргачлал

32.1.Актив удирдлагын компани банкнаас чанаргүй активыг зөвхөн зах зээлийн бодит үнээр эсхүл бодит үнээс хямдруулан шилжүүлж авна.

32.2.Хөрөнгийн зах зээлийн бодит үнийг тодорхойлохдоо Актив удирдлагын компани эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн сонгосон үнэлгээчин дараах асуудлыг харгалзан үзэж болно:

32.2.1.шилжүүлэгч банкны хөрөнгийн үнэлгээ, үнэлгээ гаргасан аргачлал;

32.2.2.шилжүүлэх активын үнэлгээ гаргахад ашиглах боломжтой Актив удирдлагын компанийн бусад мэдээ, тайлан, үнэлгээ, дүгнэлт;

32.2.3.зээлдэгч, үүрэг гүйцэтгэгчийн төлбөрийн чадвар, тухайн чанаргүй активд холбогдох үүргийн гүйцэтгэлийн түүх;

32.2.4.тухайн чанаргүй активтай ижил төстэй хөрөнгийг Актив удирдлагын компани эсхүл түүний томилсон үнэлгээчнээс үнэлж тогтоосон дүн.

32.3.Актив удирдлагын компани зах зээлийн бодит үнэ тогтоох, хямдруулах бодлого, журам тогтоон мөрдөж болно.

33 дугаар зүйл.Шилжүүлэн авсан активыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

33.1.Актив удирдлагын компани шилжүүлэн авсан чанаргүй актив, түүний барьцаа хөрөнгийг худалдан борлуулах боломжийг сайжруулах, тэдгээрийн үнэлгээг хадгалах, нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч болно:

33.1.1.тухайн хөрөнгийн хөрш залгаа эд хөрөнгө, дагалдах зүйлийг худалдан авах;

33.1.2.тухайн хөрөнгийг түрээслэх.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан арга хэмжээ авах үйл ажиллагаа явуулах шалгуур, журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

34 дүгээр зүйл.Мэргэжлийн этгээдээс үйлчилгээ авах, ажиллуулах

34.1.Актив удирдлагын компани өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шинжээч, зөвлөх зэрэг мэргэжлийн этгээдээс тухайн асуудлаар үйлчилгээ авч эсхүл тухайн этгээдийг хөлслөн ажиллуулж болно.

34.2.Актив удирдлагын компани шаардлагатай гэж үзвэл банкнаас шилжүүлэн авсан чанаргүй активыг удирдах, захиран зарцуулах этгээдийг хөлслөн ажиллуулж болно.

34.3.Актив удирдлагын компани дараах нөхцөл, шаардлагыг хангасан мэргэжлийн этгээдээс энэ хуулийн 34.1, 34.2-т заасан асуудлаар үйлчилгээ авах эсхүл ажиллуулж болно:

34.3.1. тухайн этгээд шударга, итгэл даах, мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн болон зохистой шийдвэр гаргах чадвар бүхий байх бөгөөд түүнд олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулах;

34.3.2. тухайн үйл ажиллагааг зүй зохистой явуулахад шаардлагатай нөөц боломж, арга хэрэгслийг үр дүнтэй ашиглах;

34.3.3. ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, Актив удирдлагын компанийн чиг үүрэг, үйл ажиллагаатай зөрчилдөж болох, зөрчилдөж байгаа аливаа асуудлыг ил болгох;

34.3.4. тухайн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу тавьсан аливаа шаардлагыг хангасан байх;

34.3.5. Актив удирдлагын компанид үзүүлж буй үйлчилгээтэй холбогдуулан тухайн мэргэжлийн этгээдийн санхүүгийн тайлан, данс, тайлан тэнцэлд аудитын байгууллагаар аудит хийлгэхийг зөвшөөрсөн бөгөөд аудит хийхэд бүх талаар дэмжиж ажиллах үүрэг хүлээсэн байх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

АКТИВ УДИРДЛАГЫН САН

35 дугаар зүйл. Актив удирдлагын сан

35.1. Актив удирдлагын компани тус компанид шилжиж ирсэн чанаргүй активыг шийдвэрлэх, захиран зарцуулах зорилгоор Актив удирдлагын сан (цаашид “Сан” гэх) байгуулна.

36 дугаар зүйл. Сангийн эх үүсвэр

36.1. Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

36.1.1. хувьцаа эзэмшигчээс санд оруулсан эхлэлтийн хөрөнгө;

36.1.3. Актив удирдлагын компаниас санд оруулсан хөрөнгө;

36.1.4. Актив удирдлагын компанийн шилжүүлэн авсан хөрөнгийг шийдвэрлэсэн, худалдан борлуулсны орлого;

36.1.5. зээл, тусламж, бусад санхүүжилт;

36.1.6. гадаадын банк, олон улсын санхүүгийн байгууллагаас авсан Актив удирдлагын компанийн зээл;

36.1.7. сангийн хөрөнгө оруулалтаас олсон орлого;

36.1.8. Актив удирдлагын компанийн гаргасан сангийн өрийн хэрэгслийн эх үүсвэр;

36.1.9. хуульд заасан бусад эх үүсвэр.

37 дугаар зүйл.Сангийн өрийн хэрэгсэл

37.1.Актив удирдлагын компани төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан дүрэм, бодлого, журмын дагуу тухайн компанийн шилжүүлэн авсан чанаргүй активыг шийдвэрлэх, захиран зарцуулахад шаардлагатай хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор сангийн өрийн хэрэгсэл гаргаж болно.

37.2.Төлөөлөн удирдах зөвлөл энэ хуулийн 37.1-д заасан өрийн хэрэгсэл гаргах журмыг батална.

37.3.Монгол Улсын Засгийн газар сангийн өрийн хэрэгслийн үндсэн ба хүүгийн эргэн төлөлтөд баталгаа гаргаж болно.

37.4.Актив удирдлагын компани сангийн өрийн хэрэгсэл гаргахаар төлөвлөсөн тохиолдолд гаргахаар төлөвлөсөн өрийн хэрэгслийн хэмжээ, нөхцөл, гаргах болон эргэн төлөх нөхцөлийг тодорхойлж Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

38 дугаар зүйл.Сангийн удирдлага ба үйл ажиллагаа

38.1.Актив удирдлагын компани Санг удирдан зохион байгуулна.

38.2.Сангийн хөрөнгийг дор дурдсан зорилгоор зарцуулна.

38.2.1.Энэ хуулийн 36.1.5, 36.1.6-д заасан зээлийн үндсэн болон хүүгийн эргэн төлөлт;

38.2.2.сангийн өрийн хэрэгслийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт;

38.2.3.Сангийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтын зардал;

38.2.4.Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон бусад.

38.3.Сангийн хөрөнгө энэ хуулийн 38.2-т заасан зорилгоор зарцуулах хөрөнгийн хэмжээнээс илүү гарах тохиолдолд Актив удирдлагын компани тус хөрөнгийг энэ хуулийн 38.4-д заасан журмын дагуу удирдана.

38.4.Сангийн үйл ажиллагааг зохицуулах журмыг төлөөлөн удирдах зөвлөл батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ**АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН****39 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн санхүүгийн тайлан**

39.1.Актив удирдлагын компани өөрийн үйл ажиллагааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан Актив удирдлагын компанийн нягтлан бодох бүртгэлийн тусгай журам, холбогдох олон улсын стандартын дагуу гаргах бөгөөд санхүүгийн тайланд жилд хоёроос доошгүй хөндлөнгийн аудитын байгууллагаар аудит хийлгэж, үр дүнг нийтэд ил тод мэдээлнэ.

39.2.Актив удирдлагын компани тухайн жилийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний дотор Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

39.3.Актив удирдлагын компани аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа өөрийн цахим хуудсанд байршуулна.

39.4.Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдлыг Актив удирдлагын компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

40 дүгээр зүйл. Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны тайлан

40.1.Актив удирдлагын компани жил бүр энэ хуулийн 39.2-т заасан хугацаанд тухайн жилийн үйл ажиллагааны тайланг Монголбанкны Ерөнхийлөгч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн болон Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнана.

40.2.Тайланд Актив удирдлагын компанийн үйл ажиллагааны үр дүн, компанийн засаглалын байдал, төлөөлөн удирдах зөвлөлөөс тодорхойлсон үйл ажиллагааны доголдол, дутагдал болон бусад асуудлыг тусгасан байна.

40.3.Актив удирдлагын компани энэ хуулийн 40.1-д заасан тайланг цахим хуудсандаа байршуулна.

41 дүгээр зүйл. Төрийн аудит хийх

41.1.Активын удирдлагын компанийн үйл ажиллагаанд жил бүр төрийн аудит хийнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН НЭХЭМЖЛЭЛИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦГОЙ АЖИЛЛАГАА

42 дугаар зүйл.Нэхэмжлэлийн үнийг тодорхойлох

42.1.Банкнаас энэ хуулийн дагуу шилжүүлэн авсан чанаргүй активтай холбогдуулан Актив удирдлагын компаниас гаргаж байгаа нэхэмжлэлийн шаардлагын дүнг тодорхойлохдоо зээл, зээлийн хүүг дор дурдсан хугацаанд тооцно:

42.1.1.зээл, зээлийн хүү төлөгдөх хүртэл;

42.1.2.анхан шатны шүүхийн шийдвэр гарах хүртэл;

42.1.3.төлбөр авагчийн шаардлага, эсхүл шүүхийн шийдвэрийг бүрэн болон хэсэгчлэн хангуулах зорилгоор барьцаа хөрөнгө эсхүл үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг худалдан борлуулах тохиолдолд хөрөнгийн үнэлгээ хийх хугацаанд;

42.1.4.төлбөр авагчийн шаардлага, эсхүл шүүхийн шийдвэрийг бүрэн болон хэсэгчлэн хангуулах зорилгоор барьцаа хөрөнгө, үүрэг гүйцэтгэгчийн хөрөнгийг худалдан борлуулахаар нэг болон түүнээс дээш удаа дуудлага худалдаа зохион байгуулах, худалдах хугацаанд.

43 дугаар зүйл.Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх онцгой журам

43.1.Банкнаас энэ хуулийн дагуу шилжүүлэн авсан чанаргүй активын төлбөрийг төлүүлэх, хөдлөх болон үл хөдлөх барьцаа хөрөнгө, эдгээр барьцаа хөрөнгийн эрхэд холбогдох нэхэмжлэлийг Актив удирдлагын компани шүүхэд гаргах тохиолдолд хариуцагч Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг хүлээж авснаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэлийг бүрэн болон хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эсхүл эс зөвшөөрөх талаар хариу тайлбар өгнө.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан хариу тайлбарт хариуцагч, эсхүл хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хариуцагч худал хариу тайлбар өгсөн нь тогтоогдвол хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

43.3.Хариуцагч зөвхөн дор дурдсан үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагаас татгалзаж болно:

43.2.1.Актив удирдлагын компанид төлөх аливаа өр, төлбөр байхгүй;

43.2.2.зээл болон барьцааны гэрээний үүргийг зөрчөөгүй;

43.2.3.нэхэмжлэл нь хууль зүйн болон баримтын алдаатай.

43.3.Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж буй үндэслэл, нотлох баримтыг шүүхэд ирүүлэх бөгөөд шүүх хариуцагчийн татгалзлын үндэслэл, түүнийг нотлох баримт хангалтгүй гэж үзвэл татгалзлыг хүлээж авахгүй.

43.4.Шүүх нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй бөгөөд нэхэмжлэлийн шаардлагыг нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзсэн тохиолдолд шүүх хуралдаан дээр талуудын тайлбарыг сонсож, хэрэгт цугларсан нотлох баримтыг үнэлж, онцгой журмаар хэргийг 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

43.5.Хэргийг энэ хуулийн 43.4-т заасан онцгой журмаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд зохигчид тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй.

43.6.Зохигчид анхан шат, давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлал гарснаас хойш 10 хоногийн дотор давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргаж болно.

43.7.Энэ хуулийн 42 дугаар зүйл, 43.1-43.6-д заасан Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хамаарахгүй.

44 дүгээр зүйл.Албадан дуудлага худалдаа явуулах

44.1.Энэхүү хуулийн 43 дугаар зүйлд заасан Актив удирдлагын компанийн гаргасан нэхэмжлэлийн дагуу төлбөр хариуцагчийн эд хөрөнгийг хураах шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор ахлах шийдвэр гүйцэтгэгч албадан дуудлага худалдаа явуулахаар шийдвэрлэнэ.

44.2.Албадан дуудлага худалдааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 68.2-т заасны дагуу зохион байгуулна.

45 дугаар зүйл.Нэг этгээд оролцсон дуудлага худалдаа

45.1.Дор дурдсан тохиолдолд нэг этгээд оролцсон энэ хуулийн 44.1-д заасан дуудлага худалдааг хүчин төгөлдөр гэж тооцно:

45.1.1.дуудлага худалдаа явуулах тухай зарыг зохих журмын дагуу гаргасан;

45.1.2.дуудлага худалдаанд оролцогч нь зохих дэнчин тавьсан;

45.1.3.дуудлага худалдаанд оролцогч нь зах зээлийн боломжит үнэ эсхүл дуудлага худалдаагаар худалдах хөрөнгөд санал болгох доод үнэтэй тэнцүү буюу түүнээс өндөр үнэ санал болгосон;

45.1.4.дуудлага худалдаа явуулах бусад нөхцөл, шаардлагыг хангасан.

46 дугаар зүйл.Дуудлага худалдааны үнэ

46.1.Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаагаар худалдах барьцаа хөрөнгөд санал болгох доод үнийг үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч харилцан тохиролцож тогтоосон үнээр, хэрэв тохиролцоогүй бол шинжээчийн дүгнэлтэд үндэслэн дуудлага худалдаа явуулах эрх бүхий этгээдийн тогтоосон үнээр албадан дуудлага худалдааг зохион байгуулна.

46.2.Актив удирдлагын компани энэ хуулийн 46.1-д заасан дүгнэлт хийх шинжээчийг томилно.

46.3.Анхны дуудлага худалдаагаар санал болгосон үнэд хүрэх санал гараагүй эсхүл дуудлага худалдаанд аливаа этгээд оролцоогүй тохиолдолд хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна.

46.4.Хоёр дахь дуудлага худалдааг эхний дуудлага худалдаа явуулснаас хойш 30 хоногийн дотор явуулна. Дуудлага худалдаа явуулах тухай нийтэд хуульд заасан журмаар мэдээлнэ.

47 дугаар зүйл.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх

47.1.Актив удирдлагын компанийн нэхэмжлэлийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дагуу төлбөр төлүүлэх болон Актив удирдлагын компанийн шилжүүлэн авсан чанаргүй актив, активын барьцааны үүргийг хангуулах ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 27.1.4-ийг баримтлахгүй.

47.2.Энэ хуулийн 47.1-д заасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дараах үндэслэлээр Ахлах шийдвэр гүйцэтгэгч түдгэлзүүлнэ:

47.2.1.гүйцэтгэх баримт бичигт заасан төлбөрт хураан авах эд хөрөнгийн жагсаалтаас тухайн эд хөрөнгийг хасуулах тухай, эд хөрөнгийн үнэлгээний талаар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэтэй холбогдуулан болон энэ хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан бол Ахлах шийдвэр гүйцэтгэгч гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногоос хэтрэхгүй хугацаанд шийдвэр гаргах хүртэл;

47.2.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа болон гүйцэтгэх баримт бичгийн талаар гомдол гаргасан бол гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэх хүртэл.

48 дугаар зүйл.Барьцаа хөрөнгийн дуудлага худалдааны талаар гомдол гаргах

48.1.Энэ хуулийн 45, 46 дугаар зүйлд заасан дуудлага худалдааны зөвхөн үнэлгээнд холбогдсон гомдлыг дуудлага худалдаа явуулснаас хойш 7 хоногийн дотор Ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргаж болно.

49 дүгээр зүйл.Шийдвэр гүйцэтгэгчээс бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

49.1.Актив удирдлагын компани болон түүний төлөөлөгч, төлбөр төлөгч шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй эсхүл дуудлага худалдаа хэзээ, хаана явагдсаныг мэдээгүй бол шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш долоо хоногийн дотор эсхүл дуудлага худалдаа явагдсанаас хойш долоо хоногийн дотор гомдлоо Ахлах шийдвэр гүйцэтгэгчид гаргана.

49.2.Ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 49.1-д заасан гомдлыг ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

50 дугаар зүйл.Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал

50.1.Шийдвэр гүйцэтгэгч энэ хуульд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлын тайланг Актив удирдлагын компанид сар бүр хүргүүлэх бөгөөд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гаргуулах харилцааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 118.3-д заасны дагуу зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ АКТИВ УДИРДЛАГЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООХ, ТАТАН БУУЛГАХ

51 дүгээр зүйл.Актив удирдлагын компанийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгах

51.1.Хуулиар Актив удирдлагын компанийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгаагүй тохиолдолд тус компани энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулна.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД

52 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

52.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

53 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

53.1.Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн 2028 оны ... дугаар сарын ...-ний өдрийг хүртэл дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ